



ДУНДГОВЬ АЙМАГ
БАЯНЖАРГАЛАИ СҮМСҮН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 15 өдөр

Дугаар A/36

Аргатай


Г Хуулийн хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 69 дугаар зүйлийн 69.1, 76 дугаар зүйлийн 76.1, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нөхөн болон дахин сонгууль явагдаж байгаатай холбогдуулан 2023 оны 06 дугаар сарын 17, 18, 19-ний өдрүүдэд архи, согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх, соёл урлаг, үзвэр, спортын зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах, гадаа болон битүү талбайд үйл ажиллагаа явуулдаг худалдаа, үйлчилгээний төв ажиллуулахыг хориглосугай.

2. Захирамжийг хэрэгжүүлж тухайн өдрүүдэд сумын нутаг дэвсгэрт архи, согтууруулах ундаагаар худалдаа, үйлчилгээ эрхлэх болон бусад хориглосон үйл ажиллагааг явуулахгүй байхыг иргэд, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн дарга, удирдлагуудад даалгасугай.

3. Сонгуулийн санал хураалтын үеэр иргэд, олон нийтийн хэв журмыг сахиулж, гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, иргэд сонгогчдын аюулгүй байдлыг хангаж, захирамжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг хэсгийн төлөөлөгч (С.Болдхэт), хэсгийн цагдаа (Э.Өлзий-Орших) нарт үүрэг болгосугай.



482301084

This PC/local disk(D)2023 он/ээз н актууд/захирамж 2023